



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/212

Сүхбаатар сум

Аймгийн Засаг даргын 2020 оны А/188 дугаар  
захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", "л", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд "Аймгийн Засаг даргын 2020 оны А/188 тоот захирамжийн 1 дэх заалтын "7 дугаар сарын 15-ны" өдөр хүртэлх гэснийг өөрчилж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг "2020 оны 7 дугаар сарын 31-ний" өдрийг дуустал сунгасугай.

2. Аймгийн өсвөрийн шигшээ баг, тамирчдыг бэлтгэлийг хангах хүрээнд Ерөнхий боловсролын Спортын сургуулийн спорт заалыг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу чанд мөрдөн байгууллагын хүчин чадлаас давсан үйлчлүүлэгч хүлээж авахгүйгээр ажиллуулахыг Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын Спортын сургуулийн захирал /О.Наранбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Энхбаатар/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ